

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛӨӨС ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГЭМ СЭТГЭЛ –ЗҮЙН БАЙДАЛД ТАВИХ ХЯНАЛТ, ДЭМЖЛЭГ

CONTROL AND SUPPORT THE HEALTH AND SOCIO-PSYCHOLOGICAL STATE OF A POLICE OFFICER BY CIVIL COUNCIL AT POLICE



Ш.ДОРЖХАНД Цагдаагийн Ерөнхий Газрын Гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч

DORJHAND SH. Specialist of the Department of External Relations of the National Police Agency, Police Lieutenant

П.МЯГМАРЖАРГАЛ Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Сэтгэл судлалын багш

MYAGMARJARGAL P. Lecturer in psychology of the Humanitarian University

Товч агуулга: Өнөөдөр цагдаагийн алба хаагчдын ёс зүйн аливаа дутагдал, ёс зүйн зөрчлүүд нь нэг талаас цагдаагийн алба хаагчийг хамгаалах, тэдний эрх ашиг, эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн байдлын таатай нөхцөл байдал бүрдээгүйтэй шууд холбоотой юм. Тиймээс иргэний зөвлөлөөс цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, нийгэм сэтгэл-зүйн байдалд хяналт тавих талаар тус өгүүлэлд авч үзсэн болно.

Abstract: today, from one side the shortcomings of ethics of the police officer is directly related to the fact that favorable conditions for the protection the police officer, his health, social and psychological state have not been created yet.


Therefore, this article deals with the control of health, social and psychological state of police officer by Civil Council.

1. УДИРТГАЛ

Иргэний зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны дүрмийн заалтуудаас харахад цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний хяналтын систем сайжирч, боловсронгуй болсон байгаа нь цагдаагийн ажил үйлчилгээг чанаржуулахад дөхөм болно. Тэр дундаа цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх

үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогод анхаарлаа хандуулж, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах нь цагдаагийн ажлын цаашдын хөгжил Монголын цагдаагийн байгууллагын ажилчдын чадавх, ажлын үр дүнг өсгөхөд чухал хувь нэмэр оруулах алхам болж байна.

Цагдаагийн байгууллагад шинээр Иргэний зөвлөл



байгуулагдсан нь гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгоход чухал алхам болж буй хэдий ч шинээр байгуулагдаж буй Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны дүрэмд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хяналт тавих үйл ажиллагааг ерөнхийд нь тусгасан байх ба тухайн үйл ажиллагаа хэрхэн явагдах механизм тодорхой тусгагдаагүй нь цагдаагийн алба хаагчийн сургалт хөгжлийг хэрхэн дэмжих, түүнийг тодорхойлох судалгааг гүйцэтгэх агентууд хэн болох, мөн хуулийн хэрэгжилтийг хангах, хууль сахиулах үүрэгтэй цагдаагийн алба хаагчдын эрх, тэдний аюулгүй байдал, ажил – үйлчилгээг ард иргэдэд хэвийн үзүүлэх чадамж, нийгэм сэтгэл зүйн таатай байдал бүрдсэн эсэхэд хяналт тавих талаар тодорхой зүйл заалт байхгүй байна.

Аливаа иргэдэд шууд хүрч ажилладаг, иргэдийн амьдралд шууд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд цагдаагийн байгууллага нь орчин үеийн шинжлэх ухааны салбаруудын ололтыг үйл ажиллагаандаа ашиглах нь зайлшгүй шаардлага юм. Цагдаагийн ажил нь нийгэм, сэтгэл судлал, фикик, байгалийн шинжлэх ухааны цогц мэдлэгийг ард иргэдийн амар тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, сайн сайхны төлөө ашигладаг цөөн салбаруудын нэг юм. Мөн хууль сахиулах байгууллага, тэр дундаа цагдаагийн байгууллага нь иргэд, хамт олонтой шууд харилцаа үүсгэж, шууд үйлчилгээ үзүүлэгч байгууллага болохын хувьд цагдаагийн алба хаагчаас техникийн ур чадвараас гадна харилцааны ур чадварыг эзэмшсэн байхыг шаарддаг.

Өнөөдөр цагдаагийн алба хаагчдын ёс зүйн аливаа дутагдал, ёс зүйн зөрчлүүд нь нэг талаас цагдаагийн алба хаагчийг хамгаалах, тэдний эрх ашиг, эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн байдлын таатай нөхцөл байдал бүрдээгүйтэй шууд холбоотой юм. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэдийн гомдол санал өсөх нь цагдаагийн алба хаагчийн сэтгэцийн болон сэтгэл зүйн эрүүл мэндтэй сөрөг хамааралтай байдаг гэдэг нь олон улсад хийгдсэн судалгаануудаас нотлогддог.

Иймд шинээр байгуулагдаж байгаа иргэний зөвлөл нь нэг талаас иргэдийн эрх ашиг, үйл ажиллагааны зарчим, хэрэгжилт, үйлчилгээ үзүүлж байгаа тогтолцоонд хяналт тавих, нөгөө талаас цагдаагийн ажил үйлчилгээг амжилттай явуулах, хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дэмжлэг хангагдаж байгаа эсэхэд хяналт тавьж байж цогц хяналтыг бий болох нөхцлийг бүрдүүлнэ. Дэлхийн улс орнуудын болон Монгол Улсын цагдаагийн байгууллагуудад цагдаагийн алба хаагчдын эрүүл мэнд, сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх асуудлыг сэтгэл зүйн, алба нэгж, сэтгэл зүйчдэд байгууллагуудад хариуцуулдаг. Улс орны хөгжлийн түвшин, хүн амын тоо, онцлог, газар зүйн байрлал,

үндэстний онцлог шинж чанар, байгууллагын бүтэц тогтолцоо, гэмт хэргийн хандлага зэрэг олон хүчин зүйлүүдтэй уялдуулан цагдаагийн алба хаагчдад үзүүлэх сэтгэл зүйн алба, нэгж, багийг зохицуулж ажилладаг. Тиймээс цагдаагийн байгууллагын сэтгэл зүйн алба, түүний үйл ажиллагаа, олон улсын чиг хандлага, судлагдсан байдал зэргийн талаар авч үзэж цаашид энэ салбарт Иргэний зөвлөлийн хяналтыг сайжруулах шаардлагатай.

2. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СЭТГЭЛ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫГ ТҮШИГЛЭН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА.

Бөөрөнхий дэлхий дээр хавтгай зарчмаар амьдарч байгаа энэ цаг үед улс хоорондын хил хязгаар нь хууль сахиулах байгууллагуудын бие бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагаа төдийхнөөр зааглагдаж байгаа энэ зуунд хүн төрөлхтөн, улс үндэстнүүдийн нийтлэгийн хөгжлийн чиг хандлага, үзэл бодол даярчлагдаж байгаатай зэрэгцэн гэмт хэрэг мөн адил даярчлалагдаж байна. Дэлхий дахинд тулгараад байгаа гэмт хэргүүд Монгол Улсыг тойрон өнгөрөөгүй гэдгийг сүүлийн үед гарч байгаа гэмт хэргүүдээс илхэнээ харж болно.

Иймд хуучин зуунд гэмт хэрэгтэй тэмцэж байсан арга барилаар шинэ зууны гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэлтэй учраас Монголын цагдаагийн байгууллага өндөр хөгжсөн, туршлагатай олон улсын цагдаагийн байгууллагуудтай хөл нийлүүлж алхах зайлшгүй шаардлагатай. Тиймээс Монголын цагдаагийн байгууллагад түүхэн гэгдэх дорвитой шинэчлэл идвэхитэй өрнөж байгаа. Үүний тэргүүн зорилтуудын нэг нь цагдаагийн алба хаагчийн стгэл зүйн эрүүл мэнд, харилцааны болон бусад чадваруудыг сайжруулах асуудал зүй ёсоор багтаж байгаа юм.

- “Цагдаагийн ажил хүнд мэргэжил. Цагдаагийн алба хаагч нь хүний сөрөг араншинтай дасан зохицож ажиллахыг шаарддаг бөгөөд хууль, журмыг мөрдүүлэхэд сэтгэл хөдлөлөө хянаж, үргэлж төвийг сахих хэрэгтэй болдог. /M. L. Dantzker2005/.”
- “Цагдаагийн албанд орж ажиллах хувь хүн нь цагдаагийн албан үүрэгтэй холбоотой үүсэх шаардлагыг биелүүлэх чадамжтай байхын зэрэгцээ ажилдаа сэтгэл ханамжтай байх нь чухал. (Beutler, Nussbaum, & Meredith, 1988)”
- “Ихэнхи тохиолдолд цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг эсэргүүцэгч этгээдүүтэй ажиллахад цагдаагийн алба хаагчаас харилцааны өндөр ур чадвар шаарддаг учраас цагдаагийн алба хаагчийн хувь хүний шинж, чанар харилцааны ур чадварыг нь харгалзан үзэж ажилд авах нь

зүйтэй. (Hargrave & Hiatt, 1989)".

- "Цагдаагийн алба хаагчид дунд авилгал, амиа хорлолт болон хүч хэрэглэхтэй холбоотой сэтгэл зүйн асуудлууд өндөр байдаг. Cochran, Tett, & Vandecreek, 2003); Ерөнхийдөө хууль сахиулах байгууллага нь хамгийн аюултай, эрсдэлтэй, эрүүл мэндэд хохиролтой салбар юм. (Tanigoshi, Kontos, & Remley, 2008)"

Цагдаагийн алба хаагчдын эрүүл мэнд, нийгэм – сэтгэл зүйн байдлыг сайжруулах замаар цагдаагийн албаны үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад олон төрлийн шинжлэх ухааны салбаруудын ололтуудыг ашигладагаас XX дугаар зууны сүүл үе, XXI дүгээр зууны эхэнд Сэтгэл судлалын шинжлэх ухааны ололтуудыг өргөнөөр хэрэглэж үр шимийг нь хүртсээр байна. Эдгээрийн судалгааны болон түүхэн жишээг авч үзье.

3. ЦАГДААГИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧДИЙН ХӨГЖЛИЙН ТҮҮХ

Дэлхийн цагдаагийн сэтгэл зүйчдийн хөгжлийн түүх нь хууль сахиулах ажлын хөгжилд сэтгэл судлаачдын ажил нилээдгүй хувь нэмэр оруулсныг зүй ёсоор харуулдаг. Цагдаагийн сэтгэл судлаачдын ажлын оруулсан түүхэн хувь нэмэрийг дараах үйл явдлууд болон ажлуудаас харж болно.

Хэрэгтний профайл үүсгэх

1916 онд АНУ-д цагдаагийн алба хаагчдад сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ авахаар хандсан нь цагдаагийн албаны үйл ажиллагаанд зан үйл судлалын шинжлэх ухааныг ашигласан хамгийн анхны тохиолдол гэж болох юм. Үүнээс хойш Нью-Йорк болон бусад газар барихад хэцүү гэмт хэрэгтнүүдийг мөрдөхөд сэтгэл зүйч болон сэтгэцийн эмч нарын үүсгэсэн профайлыг өргөнөөр хэрэглэх болжээ.

Цагдаагийн албанд сэтгэл зүйч ажиллуулах болсон анхны тохиолдлуудаас хэрэгтний профайл үүсгэх жишээнээс дурьдвал 16 жилийн туршид "галзуу бөмбөгчин" хэмээх Жорж Метески Нью-Йорк хотын цагдаагийн албыг төөрөлдүүлж байжээ. 1940-өөс 1956 оны хооронд тэрээр 30 гаран бөмбөгийг олон нийтийн газар байрлуулж дэлбэлсэн байна. 1956 онд бухимдсан мөрдөгчид сэтгэцийн эмч Жеймс Брюсселийг хэргийн газрын зураг, хэрэгтний үлдээсэн зурвас зэргийг судлуулахаар ажиллуулжээ. Брюссел сэжигтнийг дүрслэхдээ "Сэжигтэн эрэгтэй гэрлээгүй, гадаад, бие даан боловсрол эзэмшсэн, 50-иад насны Коннектикутад амьдардаг, сэжиглэмтгий, Кон Эдисонтой урт хугацааны маргаантай байсан" гэжээ. Түүний дүрслэл зарим талаараа хар ухаанд түшиглэсэн мэт боловч ихэнх нь сэтгэл зүйн

ойлголтууд дээр тулгуурласан байна. Жишээ нь: сэтгэцийг эмч 35 наснаас хүнд сэжиглэмтгий шинж тэмдэг илрэх өндөр боломжтой байдаг учир тэсрэх бөмбөгчин 16 жилийн өмнө анхныхаа бөмбөгийг тэсэлсэн гэж үзвэл тэрээр 50-иад насны хүн байна гэж дүгнэжээ. Түүний дүрслэл яг таарсан бөгөөд энэ нь цагдаагийн ажилчдыг хэрэгтэн рүү шууд хөтлөжээ. (LEA WINERMAN, 2004)

Хэрэгтний профайл үүсгэх ажлыг цагдаагийн мөрдөн байцаах албаны мөрдөгчид хийдэг боловч зарим нэг гэмт хэргийг мөрдөхөд сэтгэл зүйчийн профайл чухал дэмжлэгийг үзүүлдэг гэдэгтэй мэргэжилтнүүд санал нийлдэг. Ялангуяа бэлгийн сэдэлтэй гэмт хэрэг болон нийгмийн эсрэг зан төлөвийн шалтгаантай гэмт хэргүүдийг тодруулахад сэтгэл зүйчдийн гаргадаг дүгнэлт өндөр үр дүнтэй байдаг гэж үздэг (Bartol, 2008)

Хууран мэхлэлтийг илрүүлэх

Нийгэмд өчүүхэн зүйлд гэмгүй худал хэлэх нь зарим талаараа зөв байх тохиолдол байх ч хүн амины гэмт хэрэгтнийг нуун далдлах, террористуудын талаарх мэдээллийг өгөхгүй байх зэрэг нь хувь хүмүүс төдийгүй нийгмийг бүхэлд нь аюулд оруулж болдог. Тиймээс цагдаагийн алба хаагчид, шүүгчид, хамгаалалтын ажилтнууд болон бусад хуулийн мэргэжилтнүүд хууран мэхлэлтийг илрүүлэх аргыг ихээр ашигладаг. Судалгаанаас харахад Холбооны мөрдөх товчоо, Тагнуулын төв газар, Мансууруулах бодистой тэмцэх газрууд нь хууран мэхлэлтийг илрүүлэхэд сэтгэл зүйчдээс илүү амжилт гаргаж чаддаггүй байна.

Цагдаагийн зан төлөв, онцлог шинж

Нөгөө талаар цагдаагийн онцлог шинж чанар, араншин гэдэг зүйл байдаг хэдий ч энэ нь төрөлхийн биш. Цагдаагийн академид суралцахаас эхлээд хөгжиж, дуудлагаар очиж ажиллах, олон нийтэд гарч буй таагүй гэмт хэрэг, нөхцөл байдлын үед ажиллах, мөнгө зэрэг стресс үүсгэгч гадаад хүчин зүйлс, байгууллагын бодлого, гэр бүлийн хэрэгцээ, хамтран ажиллагсдын хандлага, шийдвэр гаргах, ёс зүйн асуудал зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр тэдний хувийн шинж чанар бүрэлдэн тогтдог. Trompetter, Blau, and Skolnick тусгаарлалт нь алба хаагчийн сэтгэцийг хамгаалах эсвэл урьдчилан сэргийлэх хэлбэр гэж тодорхойлсон байна. Мөн дээр дурьдсан хүчин зүйлийн нөлөөгөөр цагдаагийн алба хаагчид егзөр, хардамтгай, үнэнч, нууцлаг, сэжиглэмтгий, дээрэнгүй, захирангүй, ажиллах чадамжтай, найдвартай, шударга гэх мэт хувийн шинж чанарууд бүрэлдэн тогтдог байна. (Blau, 1994; Niederhoffer, 1967; Reiser, 1972; Schmallegger, 2005; Skolnick, 2004).



Зураг1. Цагдаагийн алба хаагчийн хувийн шинж чанарын хөгжилд нөлөөлөх бүрдэл хэсгүүд (D. Thomas, 2011)

Ажлын стресс

Үүнээс гадна үйл ажиллагааны мөн чанараар нь авч үзвэл цагдаагийн байгууллага хамгийн стресстэй байгууллагад тооцогддог. Цагдаагийн газар нь олон нийтэд үйлчилгээ үзүүлэх олон нийтийн үйлчилгээний салбарын байгууллага. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын гүйцэтгэх албан үүрэг нь үхэл амьдралын заагт байдаг бөгөөд /kill or be killed/ тодруулбал баривчлах ажиллагаанд эсэргүүцэлтэй тулгарах, албан үүргээ гүйцэтгэх үедээ хамтран ажиллагчийнхаа үхлийг харах зэрэг олон стресс үүсгэгчидтэй нүүр тулдаг. McCarty et al. (2007)-ийн хийсэн судалгааны үр дүнд цагдаагийн байгууллагад байх стресс нь жендерийн ялгаанаас үл хамааран адилхан стресс үүсгэдэг болохыг тогтоосон байна. Гэмт хэргийг шийдвэрлүүлэх удирдлаг, бусад хүмүүсээс үзүүлэх шахалт, хэт их ажлын ачаалал, удаан цагаар ажиллах, бие хүчний хүнд даалгаваруудыг гүйцэтгэх зэрэг нь цагдаагийн албан хаагчийн ажлын байрны стресс үүсгэгч хүчин зүйлүүд болж байдаг.

Цагдаагийн алба үүрэг гүйцэтгэх үед цагдаагийн алба хаагчийн ажлын байрны хувьсамтгай байдал, шилжилт хөдөлгөөн, томилгоо, болон хөндлөнгөөс дайсагнах зэрэг нөхцлүүд нь цагдаагийн алба хаагчдад итгэлгүй байдлыг бий болгодог. Стрессийн түвшин өсөхөд хувь хүний ажлын гүйцэтгэл болон бүтээмж

буурдаг. (DeFrank and Ivancevich 1998; Leka, Griffiths and Cox 2003).

Ийнхүү 1982 онд АНУ-ын Сэтгэл судлалын холбооноос хууль сахиулах байгууллагад ажилладаг сэтгэл зүйчдийн хэлтсийг бий болгосоноос хойш энэ салбарт ажилладаг сэтгэл зүйчид өөр хоорондоо харилцан туршлага солилцох, жил бүрийн давтамжтай уулзалт, зөвлөгөөн, сургалтуудыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна

Хууль сахиулах байгууллага дахь цагдаагийн сэтгэл зүйчдын эрэлт нэмэгдэж үүрэг, оролцоо өргөжсөөр цагдаагийн алба хаагчийг ажилд авахад оролцож улмаар 1968 онд Лос Анжелосын цагдаагийн газарт бүтэн цагаар сэтгэл зүйчдийг ажиллуулж эхэлсэн. Энэ үеэс эхлэн сэтгэл зүйчид барьцаалагчидтай тохиролцох, эрүүгийн гэмт хэрэгтнийг судлах, хямралт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой

үүссэн сэтгэл зүйн асуудалтай цагдаагийн алба хаагчдад зөвлөгөө өгөх гэх мэт үндсэн үүргүүдтэй ажиллах болсон.

4. ОЛОН УЛСЫН ЦАГДААГИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ

Дор цагдаагийн сэтгэл зүйч, Д.Томас-ын ангилсанаар Цагдаагийн сэтгэл зүйчдийн мэргэшлийн салбарыг үзүүлэв.



Зураг 2. Цагдаагийн сэтгэл судлаачдын үүрэг, ажлын цар хүрээ (D. Thomas, 2011)

Ерөнхийдөө олон улсын цагдаагийн сэтгэл зүйн алба, нэгжүүд дараах үндсэн 7 үүрэгтэй ажилладаг. <http://www.apa.org/monitor/julaug04/detecting.aspx>

1. Ажилтан шалгаруулж авах.

Хууль сахиулах байгууллагад шинээр ажилтан авахад цагдаагийн сэтгэл зүйчид чухал үүрэгтэй оролцдог. Цагдаагийн сэтгэл судлаачид ажилд орох өргөдөл гаргагчийн сэтгэл хөдлөлийн үзүүлэлтүүдийг сэтгэл судлалын стандарчлагдаж, найдварт чанар, болон хүчинтэй байдлыг хангасан нарийн судалгаа, шалгалтын үндсэн дээр тогтоож уг хүн хууль сахиулах байгууллагад ажиллахад тохирох эсэхэд үнэлгээ өгдөг.

Ихэнхи тохиолдолд цагдаагийн албанд тохирох эсэхэд дараах тестүүдийг нийтлэг ашиглаж ирсэн бөгөөд үүнийг "Цагдаагийн байгууллагад шинээр ажилд орох иргэнийг сонгон шалгаруулах сэтгэл зүйн шалгуур үзүүлэлт"-үүдтэй харьцуулж үнэлэлт дүгнэлт өгдөг: Оюун ухаан тест (IQ), Нийгмийн оюун ухааны тест (SQ), Сэтгэл хөдлөлийн оюун ухааны тест (EQ), Танин мэдэх тчадварын тест, Хувийн шинж чанарыг тодорхойлох тестүүд, ярилцлага. Олон улсад цагдаагийн албанд ажилд авахдаа цагдаагийн албанд тохирох эсэхийг үнэлэхдээ дараах 6 тестийг нийтлэг ашиглаж шалгаж байгаа. Үүнд: MMPI-II, IPI, CPI, Хувь хүний шинж чанарыг тодорхойлох тест (PAI), NEO хувийн шинж чанарыг тодорхойлох тест (NEO PI-R), Хувь хүний шинж чанарыг тодорхойлох 16 хүчин зүйл Factor (5th ed.; 16-PF; Craig, 2005; Dantzer & Freeberg, 2003; Jacobs, Cushenbery, & Grabarek, 2011; Kitaeff, 2010; Lee, 2006; Personnel Selection, 2005; Sanders, 2003; Weiss, Rostow, Davis, & DeCoster-Martin, 2004).

2. Албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх сэтгэл зүйн тохиромжит байдлын үнэлгээ

Нэгэнт томилогдсон алба хаагч албан үүргээ гүйцэтгэхэд сэтгэл зүйн хувьд тэр бүр бэлэн байдаггүй тохиолдлууд гардаг. Цагдаагийн алба хаагчид албан үүрэгтэй холбоотой осол гэмтэл, сэтгэл зүйн хүчин зүйлийн нөлөөгөөр цаашид албан үүргээ үргэлжлүүлэн аюулгүй, үр дүнтэй явуулж чадах эсэхтэй холбоотой асуудал тавигддаг. Удирдах албан тушаалтан өөрийн доод албан тушаалтанд асуудал тулгарсан гэж үзэхэд сэтгэл зүйн тохиромжит байдлыг үнэлгээг хийж, үр дүнг тус байгууллага, хэлтэст танилцуулдаг. Энэ нөхцөлд алба хаагч биш тус газар үйлчлүүлэгч болж байгаа учраас алба хаагчийн мэдээллийн нууцлалын асуудал хязгаарлагдмал байдаг. Ямар ч тохиолдолд алба хаагчид энэ төрлийн үнэлгээг хийх тохиолдолд урьдчилан мэдэгдэх ёстой. Олон улсын цагдаагийн дарга нарын холбооны сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх кодексд зааснаар "Үнэлгээг зөвхөн хууль сахиулах байгууллагад ажилласан туршлагатай үнэлгээ хийх

эрх бүхий сэтгэл зүйч эсвэл сэтгэл засалч хийнэ" гэж заасан байна. Мөн албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх сэтгэл зүйн тохиромжит байдлын үнэлгээг гаргахдаа эрсдлийн удирдлага, сэтгэцийн эрүүл мэндийн тест, сорил болон хөдөлмөрийн хууль болон байгууллагын зарчим зэргийг харгалзан үзэх ёстой байдаг.

3. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ

Цагдаагийн алба нь бусад ажил мэргэжилтэй харьцуулахад өндөр эрсдэлтэй орчин нөхцөлд, стресс ихтэй ажил бөгөөд үүнтэй холбоотой үүссэн хувийн асуудлуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгч туслах нь зүйн хэрэг юм.

АНУ-ын Буффаллогийн их сургуулийн Виолантигийн багийнхний 40-өөс дээш насны цагдаагийн алба хаагчдын дунд явуулсан туршилтын судалгааны үр дүнд үндэсний дундаж стандарттай харьцуулахад цагдаагийн алба хаагчдын зүрх судасны өвчлөлөөр өвдөх магадлал 10 жилээр урьд гарсан бөгөөд эмэгтэй цагдаагийн алба хаагчдын 72%, эрэгтэй цагдаагийн алба хаагчдын 43% нь холестероны хэмжээ зөвлөсөн хэмжээнээс өндөр, цусны даралтын хэмжээ дунджаас өндөр гарсан байна. "Цагдаагийн ажил үйлчилгээ нь аюултай, өндөр эрсдэлтэй, тааварлашгүй, нарийн шалгууруудтай нөхцөлд байдалд ажил үүрэг гүйцэтгэх, хүний зовлон, шаналалтай нүүр тулах зэрэг стресстэй орчин нөхцөлд ажилладаг" гэж Нью-Йоркийн цагдаагийн газарт 23 жил ажилласан, ахмад ажилтан Виоланти хэлжээ. Түүнчлэн "Энэ судалгааны үр дүнгийн талаар мэдээллийг Цагдаагийн төв байгууллагуудаас стресстэй орчин, нөхцлийг бууруулах арга хэмжээ авах байх гэж таамаглаж байна" гэжээ.

4. Онцгой үеийн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ (CSID):

Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ олон нийтийн газар удаа дараа нэгэн осол гэмтэл, эндэгдэлтэй орчин нөхцөлд ажилласан бол түүнд хямралыг даван туулах талаар ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх зайлшгүй шаардлагатай. Ихэвчлэн аваар осол болон эрдсэлтэй нөхцөл байдалд ажилласан алба хаагчид, хүн амины гэмт хэрэг, онц ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцож байгаа алба хаагчдад ослын дараах сэтгэцийн эмгэг, түгшүүрт автах, депрессд орох зэрэг сэтгэцийн ноцтой өөрчлөлтөд орох магадлал өндөр байдаг. Нөхцөл байдлын талаар алба хаагчаас мэдээлэл авч, асуудлыг сонссоноор эдгээр үйл явдлуудад дасан зохицож, үйл явдлаас үүдэн бий болох болзошгүй сэтгэл зүйн асуудлуудтай тулгарах эрсдлийг бууруулдаг.

5. Сургалт

Сургалтаар цагдаагийн алба хаагчийн харилцааны чадваруудыг нэмэгдүүлэх, стрессийг даван туулах сэтгэл зүйн хаттай байх, ярилцлага явуулах аргачлал, эрүүгийн сэтгэл зүйн сургалтууд зэрэг олон чиглэлээр, нарийвчилсан чадварт сургах сургалтуудыг сэтгэл зүйч, судлаачдын баг явуулдаг. Сэтгэл судлаачид хууль сахиулах байгууллагын шинжээчдыг сургадаг жишээ татахад Калифорнигийн Ангаахын сургууль, Сан Францискогийн их сургуулийн хүндэт доктор Паул Экпан нь 40 жилийн турш хүний нүүрний хувиралыг судлах судалгаа хийсэн байдаг. Тэрээр Оакландийн Ярилцлагад дүн шинжилгээ хийх Институт, Холбооны мөрдөх товчоо, Тагнуулын төв газар бусад холбоо, байгууллагуудын Нисэх онгоцны буудлын терроризмтой тэмцэх ажилтнууд, гадаад үйлчилгээ хариуцсан алба хаагчид, байцаагч нарт ярилцлага, байцаалт явуулах чадвар олгох сургалт явуулдаг.

Паул Экман болон Рутжерийн их сургуулийн доктор, профессор Марк Франк нар нь хүмүүсийн амьдрал, эрх чөлөө, нэр хүнд, хамтран амьдрагчидтай холбоотой эсвэл их хэмжээний мөнгө алдаж болзошгүй гэх мэт нөхцлүүдэд “Өндөр бооцоо” тавьж худал хэлдэг хүмүүсийн олон тооны жишээг судлаж, физиолог, зан байдлыг тогтоож, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж байна. Паул Экман шинэ мэдээллийнхээ ололт, үр дүнгийн талаар хэлэхдээ “Олон муухай зүйлс байна. Миний бодлоор асар том үсрэлт болох байх”-гэжээ.

6. Эрүүгийн сэтгэл зүйч

Сэтгэл зүйн шинжлэх ухааныг мэдлэгийг хууль сахиулах ажиллагаанд ашиглах нь үр дүнтэй. Эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн ховс, барьцаалагсадтай тохиролцох, зөвшилцлөөр хамгаалалт бий болгох зэрэг чадварыг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг. Энэ үйлчилгээг үзүүлдэг сэтгэл зүйчид эрүүгийн сэтгэл зүйн чиглэлээр нарийн мэргэшил эзэмшсэн байх шаардлагатай байдаг. Энэ төрлийн мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүргийг ерөнхийд нь авч үзэхэд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

7. Байгууллагын сэтгэл зүй

Сэтгэл зүйчид алба хаагчид гүйцэтгэл болон байгууллагын чадамжийг дээшлүүлэх бодлого төлөвлөлт болон хөгжлийн хөтөлбөрт боловсруулахад чухал үүрэгтэй оролцдог. Жишээ нь дор дурьдсан ажил үйлчилгээг явуулдаг.

1. Байгууллагын чадамж болон алба хаагчдын гүйцэтгэлийн хэрхэн сайжруулах хөтөлбөр боловсруулах
2. Хөгжлийн хөтөлбөрийн боловсруулахад дэмжлэг

үзүүлэх

3. Байгууллагын удирдлага болон манлайллыг нэмэгдүүлэхэд хөгжлийн хөтөлбөр боловсруулах

5. МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

2001 онд Эргүүл хамгаалалтын газар сэтгэл зүйчийн орон тоо бий болгож ажиллуулж эхэлсэн.

2007 онд төв, орон нутгийн цагдаагийн 37 нэгж байгууллагад сэтгэл зүйчийн орон тоог шинээр нэмж баталсан.

2007 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 163 дугаар тушаал, 2009 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 60 дугаартай тушаалаар сэтгэл зүйчийн ажлын байрны тодорхойлолтыг гаргасан байна.

Сүүлийн жилүүдэд гарч байгаа бүтцийн өөрчлөлтэй холбоотойгоор сэтгэл зүйчдийн орон тоог цомхотгосноос нийт 32 орон тоо байгаагаас одоо ЦЕГ-ын харьяа байгууллагад 6, орон нутагт 18, НЦГ-т 4, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн 4, нийт 30 сэтгэл зүйчид ажиллаж байна.

Одоо ажиллаж байгаа сэтгэл зүйчид нөөц, бололцоондоо тулгуурлан дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Судалгааны сан бүрдүүлэн, баяжуулан ажиллаж байна

Алба хаагчдад сэтгэл зүйн тусламж үйлчилгээ

Алба хаагчдын гэр бүлийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

Хүний нөөцийн сонгон шалгаруулалтад сэтгэл зүйн ярилцлага, сорил явуулах

Сэтгэл зүйчдийн багийн блогийн нээн ажиллуулж, цахимаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Байгууллагын сэтгэл зүйн үнэлгээ хийж, санал зөвлөмж өгөх

Алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийн хэвийн ажиллагааг хангах, хувь хүнийг чадавхжуулах сэтгэл зүйн сургалтуудыг зохион байгуулах

Хүснэгт 1. Монголын цагдаагийн байгууллагад ажиллаж буй сэтгэл зүйчдийн ажил үүргийн хуваарь, хэргэжилт болон үүргийн дахин хуваарьлалт.

Олон улсад цагдаагийн сэтгэл зүйн алба, нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа	Монгол Улсын одоогийн нөхцөл байдал		Сэтгэл зүйчдийн үүргийн дахин хуваарьлалт		
	Хэргэжилт	Тайлбар	Бүтэн цагийн цагдаагийн хэсгүүдэд ажиллаж буй зүйчид	Бүтэн цагийн цагдаагийн ерөнхий газрын зан үйл судалгааны албаны сэтгэл зүйч, судлаачид	Гэрээт сэтгэл зүйчид
1. Ажилтан сонгон шалгаруулж авах	+	2013 оноос хойш цагдаагийн албанд шинээр орохоор мэдүүлсэн хүмүүсийг сонгон шалгаруулахад сэтгэл зүйчийг оролцуулдаг болсон.ы		+	+
2. Албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэхэд сэтгэл зүйн үнэлгээ				+	
3.Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ	+	НЦГ-ын хэмжээнд 4, Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 28сэтгэл зүйчид байгууллагын 3850 алба хаагчдад үйлчилгээ үзүүлэх үзүүлэх үүрэгтэй ажиллаж байгаа нь учир дутагдалтай.			
• Алба хаагчдын хувийн асуудалд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	+		+		
• Сургалтын хөтөлбөр боловсруулах	+		+	+	+
• Алба хаагчийн албан үүрэгтэй холбоотой үүссэн стрессд зөвлөгөө өгөх	+		+	+	
• Сэтгэцийн өвчнийг даван туулах арга замд суралцахад туслах	+		+		+
• Хямралын үед тусалцаа үзүүлэх			+		
• Амиа хорлохоор завдах үеийн нөхцөл байдалд хэрхэн ажиллах			+	+	
4. Онцгой үеийн сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ	+	Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ажилласан 200 орчим алба хаагчдад ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл засал явуулсан.			
• Ганцаарчилсан сэтгэл засал			+	+	
• Бүлгийн сэтгэл засал	+		+	+	
5. Сургалт		“Цэргийн нөхөрлөл ” ТББ-ны 1 мэргэжилтэн жилд 1-2 удаагийн давтамжтай сургалт зохион байгуулдаг.			
• Хямралыг даван туулах чадвар олгох сургалт			+	+	+
• Алба хаагчдын харилцааны ур чадварыг сайжруулах сургалтууд	+		+	+	

• Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн сургалтууд			+		
• Хамтран зүтгэгчдээ сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх чадварт олгох сургалт			+		
• Эрүүгийн сэтгэл зүйн мэдлэг олгох сургалтууд				+	+
6. Эрүүгийн сэтгэл зүйч					
• Барьцаалагсадтай тохиролцох				+	
• Зөвшилцөлд хүрэхэд туслалцаа үзүүлэх				+	
• Эрүүгийн ховс хийх			+	+	
• Эрүүгийн гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх				+	
• Эрүүгийн гэмт хэрэгтний сэтгэл зүйн байдлыг тодорхойлох				+	
7. Байгууллагын сэтгэл зүй	+				
Цагдаагийн байгууллагын чадамж, алба хаагчдын гүйцэтгэлийг сайжруулах талаар судалгаанд үндэслэн хөтөлбөр боловсруулах			+	+	

6. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

- Одоо ажиллаж байгаа сэтгэл зүйчдэд мэргэжлийн удирдлага байхгүйгээс газар, хэлтсүүдэд ажиллаж байгаа сэтгэл зүйчдийн уялдаа холбоо байхгүй. Үүнээс шалтгаалан цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа сэтгэл зүйчдийн явуулж байгаа үйл ажиллагааны үр дүн бага байна.
- Монгол Улсын цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 30 сэтгэл зүйч ажиллаж байгаа нь дунджаар нэг сэтгэл зүйчид 300 орчим цагдаагийн алба хаагч оногдож байгаа нь шаардлагатай сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хангалтгүй юм.
- Цагдаагийн байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа сэтгэл зүйчдэд шаардлагатай техник хэрэгсэл, сэтгэл зүйн багаж, хэрэгсэл, сэтгэл зүйн нарийн оношилгоо, судалгааны найдварт чанар болон хүчинтэй байдлыг хангасан тестүүд байхгүй.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 937-д тусгасан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх журам нь хэт ерөнхий, алба хаагчдад хүрсэн үйл ажиллагаа явуулахад хязгаарлагдмал.

- Цагдаагийн байгууллагад ажиллах сэтгэл засалч, эрүүгийн сэтгэл зүйчид, шаардлагатай нарийн мэргэшлийн, мэргэшсэн сэтгэл зүйчид, сэтгэл засалч, байхгүй.
- Олон улсын цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа сэтгэл зүйн албадтай харилцаа холбоо байхгүй.
- Цагдаагийн байгууллагын хэмжээнд хийгдсэн цагдаагийн алба хаагчдын сэтгэл зүй, үйл ажиллагааны талаар сэтгэл судлал, бусад хавсарга шинжлэх ухааны суурь болон нарийн судалгаанууд хангалтгүй.

7. ДҮГНЭЛТ, САНАЛ

Сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллагад ажиллаж буй сэтгэл зүйчдийн үйл ажиллагаа дэвшилттэй, өөрийн цар хүрээний хувьд эрчимтэй үйл ажиллагаа явуулж буй хэдий ч ажлын загвар, бүтэц, үүргийн хуваарь ажлын ачааллыг зөв зохион байгуулаагүйгээс болж тэдний ажлын үр дүн, хүрэлцээ хангалтгүй байна. Дээрх олон улсын цагдаагийн сэтгэл зүйчдийн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээг

харахад Монголын цагдаагийн сэтгэл зүйчдийн үйл ажиллагаа орчин үеийн цагдаагийн байгууллагын хэтийн хөгжил, хууль сахиулах үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг сайжруулахад дорвитой хувь нэмэр оруулах хүний нөөцийн чадавхи хэмжээ, үйл ажиллагааны мэргэшлийн хувьд учир дутагдалтай байна

Нэгэнт цагдаагийн байгууллагад иргэний зөвлөл үүсгэн ажиллаж байгаатай холбогдуулан энэ чиглэлийн ажлыг үр дүнтэйгээр явуулах боломжийг дэмжих, хяналт тавих функцийг зөвлөлийн дүрэмд оруулах нь зүйтэй бөгөөд нөгөөтэйгүүр дэмжих, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгуур болох шинжлэх ухааны судалгаа, хэрэглээний үйл явцыг удирдах мэргэжлийн төвлөрсөн багийг байгуулах нь зүйтэй. Олон улсын туршлагаас харахад аливаа хууль сахиулах байгууллага нь сэтгэл зүй, зан үйлийн судалгааны төвлөрсөн албатай, тухайн алба нь цагдаагийн хэлтсүүдийн сэтгэл зүйн үйлчилгээ, үйл ажиллагааг орон даяар зохицуулах, шинжлэх ухаанд хууль сахиулах үйл ажиллааны хувь нэмэр оруулах үүрэгтэй ажилладаг. Шинээр сэтгэл зүй, зан үйлийн судалгааны алба байгуулах, одоо байгаа сэтгэл зүйчдийг бүтэц, зохион байгуулалтад оруулах, бусад мэргэжилтнүүд, мэргэжлийн байгууллагатай хамтран ажилласнаар одоогийн Монголын цагдаагийн сэтгэл зүйчдийн үүрэг илүү тодорхой, оновчтой, үр дүнтэй болох боломжтой. Энэ тохиолдолд цагдаагийн байгууллагын ажил илүү дэвшилтэй явагдах боломж бий болно. Иймд сэтгэл зүйчдийн үүргийн хуваарийг шинээр загварчлан /Хавсралт 1- ээс харна уу/, өнөөдрийн нөхцөл байдалтай харьцуулан дараах тодорхой саналуудыг гаргаж нэгтгэсэн болно. .

1. Цагдаагийн байгууллагад сэтгэл зүйн бие даасан алба/хэлтсийг шинээр бий болгож одоо ажиллаж байгаа сэтгэл зүйчдийг шинэ бүтэц зохион байгуулалтад оруулах
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын "Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код-937/"-ыг шинэчлэн боловсруулах
3. ЦБҮАЖ-ын "Нийтлэг болон төрөл мэргэшлийн албан тушаалтны ажил үүргийн онцлогоос тухай албан тушаалд ажиллаж буй алба хаагчийн ажлыг үнэлэх, дүгнэх үзүүлэлтэд нэмэлтээр боловсруулсан сэтгэл зүйчийн ажлыг үнэлэх, дүгнэх үзүүлэлт /код-111/-ийг шинэчлэн боловсруулах
4. ЦБҮАЖ-д "Сэтгэл зүйчийн мэргэжлийн үйл ажиллагааны ёс зүйн дүрэм"-ийг шинээр нэмж тусгах
5. Сэтгэл зүйчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх
6. Одоо ажиллаж байгаа цагдаагийн сэтгэл зүйчдийг "Олон улсын цагдаагийн дарга нарын холбоо"-ны Police Psychological Services Section Agenda нэгдэж орох

7. Мөрдөн байцаагчид, сэтгэл зүйчид, сэтгэл засалчид, криминологчидийг нарийн мэргэшлийн сургалтад хамруулах
8. Хуулийн сэтгэл зүйчээр бэлтгэдэг дотоодын болон олон улсын их дээд сургуулиудад цагдаагийн албанд ажиллаж байгаа сэтгэл зүйчид, криминологчидийг суралцуулах.
9. Одоо ажиллаж байгаа сэтгэл зүйчдийг хөгжүүлэх, чадвар
10. Олон улсад цагдаагийн байгууллагуудад ашиглагдаж байгаа сэтгэл зүйн оношилгооны тест, багаж, техник хэрэгслүүдээр хангах
11. Сэтгэл зүйн зөвлөгөөний тусгай өрөөгөөр хангах
12. Сэтгэл засалчдыг цагдаагийн албанд оруулах

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Монгол эх сурвалж

МУИС-ын судалгааны архив

Цагдаагийн албаны тухай хууль 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код. 2013 он

Гадаад эх сурвалж

Abigail S. Malcolm, MS, Jessica Seaton, MS, Aimee Perera, PsyD, Donald C. Sheehan, MA Vincent B. Van Hasselt, PhD: Critical Incident Stress Debriefing and Law Enforcement

Bowler RM1, Harris M, Li J, Gocheva V, Stellman SD, Wilson K, Alper H, Schwarzer R, Cone JE .Longitudinal mental health impact among police responders to the 9/11 terrorist attack

Chris Hatcher, Ph.D.,* Kris Mohandie, Ph.D., Jim Turner, Ph.D., and Michael G.Gelles, Psy.D. The Role of the Psychologist in Crisis/Hostage Negotiations

Jack Kitaeff, Edwin A. Fleishman, George Mason University, Jeanette N. Cleveland, Pennsylvania State University, Series Editors "Handbook of police psychology" - SERIES IN APPLIED PSYCHOLOGY

Jack A. Digliani: Law Enforcement - Critical Incident Handbook

Jon M. Shane. Organizational stressors and police performance in John Jay College of Criminal Justice, Department of Law and Police Science, 899 Tenth Avenue, New York, NY 10019, United States

Laurence Miller, PhD: The Psychological Fitness-For-Duty Evaluation

Laurence Miller. Law Enforcement Traumatic Stress: Clinical Syndromes and Intervention Strategies

Dr. Laurence Miller. Police Personality: Fact or Fiction

Lea Winerman. 2004. "Criminal profiling: the reality behind the myth" research

Mark Costanzo, Claremont McKenna College, Daniel Krauss, Claremont McKenna College ., 2012: Forensic and Legal Psychology - Journal of Police and Criminal Psychology, 2005, Volume 20, Number 1

Muhammad Hammad 1+, Sajid H. Awan 1, C. S. Akhtar 2 and Muhammad Imdadullah

1 SZABIST. Investigating Stress and Employee Performance in Traffic Police. Islamabad Pakistan2 Universiti Teknologi Malaysia, Malaysia

O.A. Afolabi, R.K. Awosola and S.O. Omole. Influence of Emotional Intelligence and Gender on Job Performance and Job Satisfaction among Nigerian Policemen. Department of Psychology, Ambrose Alli University, Ekpoma, Edo State, Nigeria

Pecalba V, McGuire H, Leite JR. Psychosocial interventions for prevention of psychological disorders in law enforcement officers (Review)

Robert W. Balch. 1972. Journal of Criminal Law and Criminology: Hostage negotiations: Psychological strategies for resolving crises

Robert e. Cochrane, robert p. Tett, leon Vandecreek: "Selection of police officers" - A National Survey

The Pre-employment Clinical Assessment of Police Candidates: Principles and Guidelines for Canadian Psychologists April, 2013

The Police and mental health guide was first launched in 2010.

http://www17.griffith.edu.au/cis/p_cat/admission.asp?ProgCode=5326&Type=apply

<http://www.ntu.edu.sg/HSS/Psychology/programmes/undergraduate/Pages/Courses.aspx>

«Sarlito Warawan - Indonesian psychologist». Retrieved 8 October 2010.

«Master of Social Sciences in Clinical Psychology». Retrieved 1 October 2010.

"Master of Psychology (Forensic)". Retrieved 1 October 2010.

http://markzelig.com/wp/?page_id=42

http://www.policechiefmagazine.org/magazine/index.cfm?fuseaction=display_arch&article_id=2446&issue_id=82011

http://www.policechiefmagazine.org/magazine/index.cfm?fuseaction=display_arch&article_id=2446&issue_id=82011

<http://en.wikipedia.org/wiki/Police_psychology>

<http://www.buffalo.edu/news/releases/2008/09/9660.html#sthash.05RYQbot.dpuf>

Интернет эх сурвалж

<http://www.apa.org/monitor/jun02/force.aspx>

http://www.policechiefmagazine.org/magazine/index.cfm?fuseaction=display_arch&article_id=1646&issue_id=102008

<http://what-when-how.com/police-science/psychology-and-the-police/>

http://trace.tennessee.edu/cgi/viewcontent.cgi?article=2127&context=utk_chanhonoproj

http://www.spf.gov.sg/prints/annual/2008/08spfa_features_people.htm

<http://app.hta.gov.sg/HTACollocatedSchoolsandUnits/BehaviouralSciencesUnit/tabid/127/Default.aspx>

<http://psychweb.cisat.jmu.edu/spcp/about.html>

http://www.theiacp.org/div_sec_com/sections/psych.htm

<http://www.liv.ac.uk/psychology/ccir/op.html>

«Centre For Investigative Psychology». Retrieved 1 October 2010.

<http://www.le.ac.uk/pc/cap/forensic/appliedforensic/forappdlcourse.html>

"M.Sc. Investigative & Forensic Psychology". Retrieved 8 October 2010.